



“ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2021 оны 3 сарын 30 өдөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,
Төмөрчний гудамж - 8, 405 тоот
Утас: 1976 7711-4519, 88472789, 88112654
И-мэйл: leaderaudit.20@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ТЕХНИК ИМПОРТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санал дүгнэлт

Бид Техник импорт ХК (цаашид “компани” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Техник импорт ХК -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын сандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй болгоход шаардлагатай байдаг.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бусад

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Техник импорт ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-ийн

Захирал



Т. Шаравхорол